



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 1/66

Улаанбаатар хот

Шагналын журам шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн долоо дугаар заалт, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн гишүүдийн 2013 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Үндэсний статистикийн салбарын шагналын ерөнхий журмыг I, Үндэсний статистикийн салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүний /анкет/ тодорхойлолтын загварыг II, Үндэсний статистикийн салбарын шагналын эх загварын тодорхойлолтыг III, Хүндэт дэвтрийн хавтасны загварыг IV, дэвтрийн дотор загварыг V, Дурсгалын гэрчилгээний загварыг VI, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтны үнэмлэхний загварыг VII, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтны цол тэмдгийн загварыг VIII, Хүндэт жуухын загварыг IX хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан "Шагналын журам шинэчлэн батлах тухай" Үндэсний статистикийн газрын даргын 2004 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дүгээр, 2006 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/02 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Энэхүү тушаалыг салбарын болон төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлэн танилцуулж, хэрэгжүүлэхийг Төрийн захиргаа удирдлагын газрын дарга (Т.Гантөмөр)-д даалгасугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН САЛБАРЫН ШАГНАЛЫН ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний хэмжээний статистикийн мэдээллийн тогтолцоо, арга зүй, үйл ажиллагааг боловсронгуй болгон хөгжүүлэх, статистикийн албадыг бэхжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан, Монгол Улсын статистикийн салбарын ажилтнуудын идэвх санаачлагыг өрнүүлэх, хөдөлмөр бүтээлийг үнэлэх, алдар гавьяаг мөнхжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Үндэсний статистикийн хорооны шагнал нь дор дурдсан төрлөөс бүрдэнэ.

1.2.1. Үндэсний статистикийн хорооны “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь мөнхжүүлж, дурсгалын үнэмлэх олгох

1.2.2. “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг

1.2.3. Үндэсний статистикийн хорооны “Хүндэт жуух”

Хоёр . Шагналын тодорхойлолт

2.1. “Хүндэт дэвтэр”-т мөнхжүүлж, дурсгалын гэрчилгээ олгох

Хүндэт дэвтэрт бичиж алдаршуулах нь Үндэсний статистикийн салбарын дээд шагналын нэгэн төрөл мөн. Үндэсний статистикийн хорооны “Хүндэт дэвтэр”-т бичиж урамшуулахын зорилго нь тус салбарын хөгжлийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлон хэрэгжүүлэх, хүний нөөц, техник, технологи, төсөв, санхүүгийн үндэсний чадавхийг бэхжүүлэх; статистикийн мэдээллийн тогтолцоо, арга зүйг боловсронгуй болгох, мэдээлэл судалгааны дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх чиглэлээр түүхэн тодорхой цаг үед онцгой гавьяа байгуулж, гарамгай үйлс бүтээсэн тухайн ажилтны салбарын нийт хамт олны итгэл, хүндэтгэлийг хүлээж, тэдний зүй ёсны бахархал, үлгэр дуурайлал нь болох чанар, ажил үйлсийг нь мөнхжүүлэн алдаршуулахад оршино.

2.2. “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг

“Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг нь Үндэсний статистикийн салбарын “дээд” шагнал юм.

2.3. *Үндэсний статистикийн хорооны “Хүндэт жуух”*

Хүндэт жуух нь Үндэсний статистикийн байгууллагын нэрийн өмнөөс олгогддог салбарын хэмжээний нэр хүндтэй шагналын нэг юм.

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Үндэсний статистикийн хорооны “Хүндэт дэвтэр”-т бичиж хөдөлмөр бүтээлийг нь мөнхжүүлэн үлдээх хүний асуудлыг, дор дурдсан болзол, нөхцөлийг үндэслэн тус хорооны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

3.1.1. Үндэсний статистикийн салбарт 25-аас доошгүй жил ажиллаж, хөдөлмөр бүтээлийн онцгой амжилт гаргаж төр, засгийн дээд шагнал болон салбарын тэргүүний ажилтан цол, тэмдэг хүртсэн ахмад хүмүүсийн туулж ирсэн ажил, амьдралын ололт, амжилт, бүтээл туурвил, санаачлан хийсэн ажил үйлсийг нь үндэслэнэ.

3.1.2. Статистикийн салбарт 25-аас доош жил ажилласан боловч тус салбарын хөгжилд өөрийн оюун ухаан, мэдлэг боловсролоо дайчлан онцгой гавьяа, гарамгай амжилт гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа шилдэг, тэргүүний ажилтны хөдөлмөр, бүтээл, идэвх санаачлагыг хөхүүлэн урамшуулах, идэвхжүүлэх шаардлагыг харгалзана.

3.1.3. Статистикийн салбарыг хөгжүүлж бэхжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан төр, Засгийн болон гадаад орон, олон улсын байгууллагуудын ажилтны хичээл зүтгэлийг үнэлж урамшуулна.

3.1.4. Монгол Улсын “Хөдөлмөрийн баатар”, “Гавьяат” зэрэг төрийн дээд цолоор шагнуулсан статистикийн салбарын ажилтны Улсын хэмжээнд үнэлэгдсэн гавьяа, нэр төр, бүтээл, туурвилын үнэ цэнийг алдаршуулж мөнхжүүлнэ.

3.2. **“Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдэг**

Уг шагналыг дор дурдсан болзлыг хангасан нөхцөлд олгоно. Үүнд:

3.2.1. Үндэсний статистикийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, статистикийн мэдээллийн тогтолцоог олон улсын нийтлэг аргачлал, стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, статистикийн мэдээлэл, тооллого судалгааны үнэн бодит байдлыг хангах талаар идэвх чармайлт гаргаж онцгой гавьяа байгуулсан; улс орны нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг тооцох, орчин үеийн боловсронгуй арга, технологи (корреляци, регресс, математик-статистик-эконометрикийн аргууд болон компьютер, программ хангамж, загварчлал зэрэг)-ийг ашиглан томоохон тооллого, суурь судалгааны ажлыг дангаараа болон хамтран гүйцэтгэж

улмаар дорвитой бүтээл болгон практикт нэвтрүүлж, хэрэглэгчдийн хүртээл болгосон, статистикийн мэдээллийн сан, удирдлагын мэдээлэл (динамик)-ийг бүрдүүлж, статистикийн үйл ажиллагаанд хэвшүүлсэн;

3.2.2. Үндэсний статистикийн алба болон статистик, бүртгэл, тооцооны салбарт 10-аас доошгүй жил ажилласан, онцгой үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг **“Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан”** цол, тэмдгээр шагнана.

3.2.3. Статистикийн салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан, уг шагналын болзлыг хангасан хүмүүсийг цол тэмдгээр шагнаж болно.

3.3. **“Хүндэт жуух”**-ыг Үндэсний статистикийн алба болон статистик, бүртгэл, тооцооны салбарт 8-аас доошгүй жил ажилласан, онцгой үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг хөдөлмөр бүтээл, ажлын идэвхийг өрнүүлэх, бүтээлч санаачлагыг нь хөхүүлэн дэмжих чиглэлээр олгоно.

3.4. Статистикийн албаны материаллаг баазыг бэхжүүлэх, чадавхийг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, дадлагажуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан төр, засгийн болон гадаад орон, олон улсын байгууллагын ажилтан, их дээд сургуулийн эрдэмтэн багш нар, байнгын хамтын ажиллагаатай бусад байгууллагуудын эдийн засгийн мэргэжлийн ажилтнуудыг ажлын үр дүнг нь харгалзан Үндэсний статистикийн салбарын аль нэгэн шагналаар шагнаж болно.

3.5. Статистикийн салбарын шагналаар шагнахдаа тухайн хүний урьд авч байсан шагнал урамшлыг харгалзан, шагналын эрэмбэ дараалал, зэрэг зиндааг алдагдуулахгүй байх зарчим баримтлана.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. **“Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан”** цол, тэмдэг болон ҮСХ-ны бусад шагналд нэр дэвшигдэж байгаа хүн нь энэ журмын гуравдугаар хэсэгт заасан шагналын болзлыг хангасан байх ба өмнө авсан шагналаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээсээ ахисан нөхцөлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ. Онцгой амжилт бүтээл гаргасан тохиолдолд хугацаанаас нь өмнө шагнал олгуулахаар тодорхойлж болно.

4.2. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүнийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ. Үүнд:

4.2.1. Батлагдсан загварын дагуу шагналд өргөн мэдүүлсэн хүний анкет;

4.2.2. Ажил байдлын тодорхойлолт, шагнуулах үндэслэл;

4.2.3. Шагналд тодорхойлсон байгууллагын удирдлагын гарын үсэгтэй албан бичигтэй байх ба тухайн байгууллагын харьяалах Засаг захиргааны нэгжийн болон тухайн шатны статистикийн (газар, хэлтэс) албанаас дэмжсэн тодорхойлолт, хүсэлтээр (албан бичгээр) баталгаажуулсан байна.

4.2.4. “Хүндэт дэвтэр”-т бичүүлэхээр тодорхойлсон хүний материалд 6х9, 6х4 хэмжээний тус тус 1 хувь гэрэл зураг ирүүлнэ.

4.3. Шагналд нэр дэвшигдсэн хүний ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын амжилт бүтээлийг нь товч тодорхой бичсэн байх бөгөөд мөн онцгой амжилт гаргасан ажил бүтээлийн жагсаалт, үзүүлэлтийг дурьдсан байна.

4.4. Шагналд тодорхойлсон материалыг тухайн хүнийг шагнуулахаар товлосон хугацаанаас нэг сарын өмнө ҮСХ-нд ирүүлсэн байна.

4.5. ҮСХ-нд ирүүлсэн шагналын материалыг тухайн байгууллага, хувь хүнд буцаан олгохгүй бөгөөд шийдвэрийн талаар хариуг мэдэгдэнэ.

4.6. Шагналын гэрчилгээ, тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн хүн дахин авах бол уг шагналын эзэн эсхүл түүний итгэмжлэгдсэн хүнд, өргөдөл холбогдох бичиг баримтыг үндэслэн гэрчилгээ, тэмдэг, үнэмлэхийг дахин олгох эсэхийг ҮСХ-ны даргаас зөвшөөрөл авч Дурсгалын гэрчилгээг 5000 /таван мянга/, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтны тэмдгийг 20000 /хорин мянга/, түүний үнэмлэхийг 5000 /таван мянга/, ҮСХ-ны “Хүндэт жуух”-ыг 6000 /зургаан мянган төгрөг/ төгрөг төлсөн баримтыг үндэслэн нөхөн олгож болно.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Шагналын журмын дагуу бүрдүүлж ирүүлсэн тодорхойлолт, материал, шагнуулах болзол, шаардлага хангасан хүмүүсийн талаар ҮСХ-ны Төрийн захиргааны асуудал эрхэлсэн газар нэгж хүлээн авч, даргын зөвлөлийн холбогдох гишүүдэд танилцуулан саналын дагуу онцгойлон үзэхээс бусад тохиолдолд жилд хоёр удаа (хагас, бүтэн жилээр) ҮСХ-ны даргын шийдвэрээр уг шагналыг олгоно.

5.2. Шагналыг шагнагдсан хүнд өөрт нь буюу эсхүл тухайн хүнийг шагналд тодорхойлсон байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчид гардуулан өгнө.

Зургаа. Шагналын дагалдах мөнгөн шагнал

6.1. ҮСХ-ны “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь мөнхжүүлж, гэрчилгээ олгоход 500,000 /таван зуун мянга/ төгрөг, “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнахад 200,000 /хоёр зуун мянга/ төгрөг, ҮСХ-ны “Хүндэт жуух”-аар шагнахад 80,000 /наян мянга/ төгрөгийн дагалдах мөнгөн урамшууллыг олгоно.

6.2 Дагалдах мөнгөн урамшууллыг тухайн шагналд тодорхойлсон үндсэн байгууллагаас нь олгоно.

6.3. ҮСХ-ны “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь мөнхжүүлсэн, “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, ҮСХ-ны “Хүндэт жуух”-аар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагналыг олгохгүй байж болно.

-----oOo-----

Статистикийн салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүний /анкет/ тодорхойлолтын загвар

20... оны... дугаар сарын... өдөр

Зураг
4x6

1. Эцэг, эхийн нэр
2. Өөрийн нэр
3. Ургийн овог
4. Хүйс
5. Регистрийн дугаар.....
6. Үндсэн захиргаа
7. Боловсролын талаар (өрөнхий, тусгай дунд, дээд боловсрол, дипломын, бакалаврын болон магистрийн зэргийг оролцуулна)-Х мэдээлэл

Сургуулийн нэр	Орсон он, сар	Төгссөн он, сар	Эзэмшсэн боловсрол, мэргэжил, гэрчилгээ, дипломын дугаар

8. Туршлагын талаарх мэдээлэл
 Улсад ажилласан нийт жил.....
 Үүнээс: Статистикийн салбарт.....
 Бүртгэл эдийн засгийн салбарт.....

Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Ажилласан байгууллага, газар, түүний хэлтэс	Албан тушаалын нэр	Ажилд орсон он, сар	Ажлаас гарсан он, сар

9. Төр, засгийн ямар шагналаар хэзээ шагнагдсан

Шагналын нэр	Зарлиг, захирамж, тушаалын нэр, он, сар, өдөр, дугаар	Үнэмлэхний дугаар	Шагнал олгосон үндэслэл, тайлбар

10. Бусад ямар төрлийн шагналаар шагнагдсан.

.....

11. Шагналын нэр, шагнуулах үндэслэл.

.....

-----oOo-----

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН САЛБАРЫН ШАГНАЛЫН ЭХ ЗАГВАРЫН ТОДОРХОЙЛОЛТ

1. “Хүндэт дэвтэр”

Үндэсний статистикийн хорооны **Хүндэт дэвтэр** нь дор дурьдсан тодорхойлолт, загварын дагуу бэлтгэсэн хавтас, хэвлэмэл хуудас, мөн дурсгалын гэрчилгээ гэсэн бүрдэл хэсэгтэй байна.

1.1. **Тодорхойлолт**, “Хүндэт дэвтэр” нь 470x307 мм-ийн хэмжээтэй битүү бүрсэн хатуу хавтастай, нэгдсэн дугаар бүхий тусгай загварын дагуу хэвлэсэн хуудастай байна.

1.1.1. Хавтасны гадна талыг хар хөх өнгийн материалаар (арьсан болон хэвлэлийн зориулалтын) бүрсэн байх ба байгууллагын үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн лого, МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР гэсэн бичвэрийг хавтасны дээд хэсэгт, түүний дор гол хэсэгт нь “ХҮНДЭТ ДЭВТЭР”, доод хэсэгт Улаанбаатар хот гэсэн бичвэрийг дардас байдлаар үйлдэнэ.

1.1.2. “Хүндэт дэвтэр”-ийн хавтасны нүүр хэсгийн лого, бичвэр нь алтадмал шар өнгөтэй байна. “Хүндэт дэвтэр”-ийн дотор эхний хуудсыг “Түмэн наст” хээгээр зураглан голд нь “Соёмбо” байрлуулсан байна. Хуудасны доторх хүрээ, “Соёмбо” нь алтадмал шаргал өнгөтэй байна.

1.2. “Хүндэт дэвтэр”-ийн хуудас нь 210x307 мм хэмжээний зузаан (картонон) материалаар хийгдэж, хуудас хоорондоо нимгэн калькан цаасаар тусгаарлагдсан байх бөгөөд хуудсыг захны ирмэгнээс нь 0,5 см зайтайгаар цагаан цэнхэр өнгийн алхан хээгээр хүрээлсэн байна.

1.2.1. “Хүндэт дэвтэр”-ийн хуудасны дээд төв хэсэгт ... дугаар, хүндэт дэвтэрт бичигдсэн хүний 6x9 хэмжээний цээж зургийг байрлуулж, түүний овог, нэрийг хар өнгийн бэхээр, гараар (тод) цэвэрхэн бичсэн байна.

1.2.2. Хуудасны талаас доошхи хэсэгт түүний байгуулсан гавьяа, хийж бүтээсэн ажил зэргээс нь товч тодорхой тэмдэглэн оруулж, Үндэсний

статистикийн хорооны даргын оны ... сарын ... өдрийн шийдвэрээр бичигдэх болсныг баталгаажуулан тэмдэглэсэн байна.

1.3. “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн хүнд уг хүндэтгэлийн арга хэмжээг нь баталгаажуулсан “Дурсгалын гэрчилгээ”-г олгож, үүрд хадгалуулна.

1.3.1. “Дурсгалын гэрчилгээ” нь энэ журмын хавсралтад дурдсан загварын 215x156 мм хэмжээний улаан хүрэн өнгийн хавтас, тусдаа салангид (авч болох) 210x146 мм хэвлэмэл дотор хэсгээс бүрдэнэ.

1.3.2. “Дурсгалын гэрчилгээ”-ний хавтас нүүрэн талын гол хэсэгт “Соёмбо”, түүний дор “Дурсгалын гэрчилгээ” гэсэн бичвэрийг дардас байдлаар үйлдэнэ.

1.3.3. “Дурсгалын гэрчилгээ”-ний дотор нь дундуураа нугалмал байдлаар хоёр хэсэгт хуваагдсан байна.

1.3.4. “Дурсгалын гэрчилгээ”-ний зүүн дээд хэсэгт ГЭРЧИЛГЭЭ, “Дугаар ...” гэсний дор тухайн хүний 6x4 хэмжээний цээж зургийг байрлуулж, дор нь ны.....танаа гэж овог, нэрийг бүтнээр нь тод, цэвэрхэн бичсэн байна.

1.3.5. “Дурсгалын гэрчилгээ”-ний баруун дээд хэсэгт “Үндэсний статистикийн хөгжилд оруулсан таны хичээл зүтгэл, гарамгай амжилт, алдар гавьяаг тань үнэлж Үндэсний статистикийн хорооны хүндэт дэвтэрт бичиж, алдаршуулан мөнхжүүлсний батламж болгож энэхүү дурсгалын гэрчилгээг олгов” гэсэн хэвлэмэл (алтадмал) бичвэртэй байна. Үүний дор ҮСХ-ны даргын гарын үсэг, огноо, байгууллагын тамга дарсан байна.

1.4. “Дурсгалын гэрчилгээ”-ний дугаар нь “Хүндэт дэвтэр”-ийн дугаартай нэг адил байна.

2. “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг

2.1. “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдэг нь дор дурдсан загвар, тодорхойлолтын дагуу хийгдсэн байна.

2.2. “Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдгийн дээд гол хэсэгт товгор алтан шармал соёмботой, соёмбоны хоёр хажуу талаар алтан шармал амуу буудайн товгор зурагтай, тэмдгийн дунд доод хэсэгт **Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан** гэсэн бичвэрийг алтан шармалаар товгойлгон бичсэн бичвэрийн доод суурь нь улаан хүрэн өнгөтэй, тэмдэгний их бие нь сүлдний доод хэсгээс өнцөг гарган цацарсан мөнгөлөг өнгөтэй байна.

3. “Хүндэт жуух”

3.1. “Хүндэт жуух” нь энэ журмын хавсралтад дурдсан загварын дагуу 210 x 297 мм хэмжээтэй 150 граммын шохойтой цаасан дээр дэлгэмэл байдлаар хэвлэгдсэн байна.

3.2. “Хүндэт жуух” нь улаан хүрэн өнгийн хавтастай байна.

3.3. “Хүндэт жуух”-ын хавтасны гадна талд Монгол Улсын сүлдийг байрлуулж түүний дор “Хүндэт жуух” гэсэн бичвэртэй байна.

3.4. “Хүндэт жуух”-ын дотор нь цайвар цагаан өнгөт, алхан хээгээр хүрээлүүлсэн байх ба түүний зүүн дээд хэсгийн голд нь “Соёмбо” байрлуулна.


3.5. “Хүндэт жуух” нь дугаар, овог нэрийг бүтнээр нь бичиж, “Таныг статистикийн албыг хөгжүүлэх, мэдээллийн тогтолцоо, технологийг боловсронгуй болгох, мэдээ тайлангийн үнэн зөв, бодит байдлыг хангахад оруулсан хувь нэмрийг тань үнэлж Үндэсний статистикийн хорооны “Хүндэт жуух”-аар шагнав” гэсэн хэвлэмэл бичвэр (хэвлэмэл бичээс нь алтадмал байх), байгууллагын даргын гарын үсэг, он сар өдөр, тамга дарсан байна.

-----oOo-----


ҮСХ-ын даргын 20¹³ оны 5-р сарын
23 өдрийн 16 тоот тушаалын IV хавсралт

“Хүндэт дэвтэр”-ийн загвар

а) Хүндэт дэвтэрийн ерөнхий загвар



б) Хавтасны нүүрэн тал




ҮСХ-ын даргын 2013 оны ...-р сарын
25 өдрийн 1/6 тоот тушаалын V хавсралт

в) Хавтасны арын дотор тал



г) Хүндэт дэвтэрийн хуудасны загвар




ҮСХ-ын даргын 20¹⁵ оны ...-р сарын
23 өдрийн 16 тоот тушаалын VI хавсралт

“Дурсгалын гэрчилгээ”-ний загвар

а) Хавтасны нүүр тал



б) Гэрчилгээний дотор тал



ҮСХ-ны даргын 20 ¹³ оны ⁵-р сарын
²³ өдрийн ¹⁶ тоот тушаалын VII хавсралт

“Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан үнэмлэх”-ний загвар

а) Үнэмлэхний нүүрэн тал



б) Үнэмлэхний дотор тал

140 мм

90 мм

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО

Тань

Статистик, бүртгэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг өндөрөө үнэлж, Үндэсний статистикийн салбарын дээд шагнал

“БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”

цол тэмдгээр шагнаж, үнэмлэх олгов

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА


Дугаар

оны сарын

Нар

ҮСХ-ны даргын 20^{᠘᠘} оны ᠑-р сарын
᠒᠓ өдрийн 1/᠖᠖ тоот тушаалын VIII хавсралт


“Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдэгний загвар



ҮСХ-ын даргын 20¹¹ оны 5-р сарын
23 өдрийн 1/6 боот тушаалын IX хавсралт

“Хүндэт жуух”-ын загвар

а) Хавтасны нүүрэн тал



б) Хүндэт жуухын дотор тал

